



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2024 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 102

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө данснаас хасах,
бүртгэх зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн 4 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дундговь аймгийн Төрийн аудитын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоосон, 35,000,000.00 (гучин таван сая) төгрөгийн балансын үнэ, 14,583,333.00 (арван дөрвөн сая таван зуун наян гурван мянга гурван зуун гучин гурав) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий Ниссан патрол маркийн автомашиныг хавсралтад заасны дагуу төрийн өмчийн данс бүртгэлээс хасч, Дорнод аймгийн Халхгол сумын Засаг даргын Тамгын газрын данс бүртгэлд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга тэргүүн аудитор С.Цэрэнбаяр, Дорнод аймгийн Халхгол сумын Засаг даргын Тамгын газрын дарга Х.Хүрэл-Эрдэнэ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх, засаж сэлбэн ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл) т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
132001112

8-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2024 оны... дугаар сарын... өдрийн
 ... дугаар албан бичгийн хавсралт

ДУНДГОВЬ АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ДАНС БҮРТГЭЛЭЭС ХАСЧ,
 ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

№	Тээврийн хэрэгслийн нэр	Марк	Улсын бүртгэл		Үйлдвэр-лэсэн он	Ашиглалтанд орсон он	Тээврийн хэрэгслийн үзүүлэлт			Гүйлт	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
			Сери	Дугаар			Арлын дугаар	Моторын дугаар	Моторын эзэлхүүн				
1	Ниссан патрол	У-61	ДУА	00-09	2011	12/22/2011	JN1TCSY61Z0579295	216450	4169, B	145,948	35,000,000.00	14,583,333.00	20,416,667.00
											(гучин таван сая)	(арван дөрвөн сая таван зуун наян гурван мянга гурван зуун гучин гурав)	(хорин сая дөрвөн зуун арван зургаан мянга зургаан зуун жаран долоо)